

**Монгол бичгийн зөв бичих дүрмээр эртний монгол
хэлний хэв шинжийг тодруулах боломж**

Профессор Ш. Чоймаа*

Аливаа улс үндэстэн бичгийн хэлээ эрхэмлэн чухалчилдаг бөгөөд хэл шинжлэлийн ухаанд “*бичгийн хэл*” гэдгийг, зөв бичих зүй, зөв дуудах зүй, хэл зүй, найруулгазүйн тогтсон хэм хэмжээтэй, сайтар боловсорсон хэл юм гэж үздэг.

Тухайн үндэстний оюуны соёлын өв уламжлалын хэр хэмжээг тодорхойлох гол хэмжүүр нь бичгийн соёл мөн бөгөөд үүнд, хэдийд бичиг үсэгтэй болсон бэ?, тэрхүү бичиг үсгээрх сан хөмрөг нь хэр арвин байдаг вэ?, хэдий үед бичгийн хэл нь бүрэн цэгцэрсэн бэ? зэрэг асуудлыг нарийвчлан авч үзэх хэрэгтэй болдог байна. Энэ талаар монгол бичгийн хэл нь их эртний уламжлалтай.

Монголчууд монгол бичгийг хэрэглэж эхэлсэн он цагийн тухайд эрдэмтэн судлаачдын санал адилгүй боловч, “*Монгол бичгийн хэл анх үүсэн бүрэлдсэн цаг үеийг манай эриний IX-X зууны үед хамааруулан үзэх нь үнэнд илүү ойр болно*”¹ гэсэн гол баримтлалыг ихэнх монголч эрдэмтэн хүлээн зөвшөөрчээ.

Учир нь, өдгөө бидэнд уламжлан үлдсэн монгол бичгийн дурсгалуудын холбогдох цаг хугацаа нь XIII зууны эхэн үеэс эхлэх боловч тэдгээр дурсгалын хэлийг судлан үзвэл, шинэ тутам бүрэлдэн тогтсон бичгийн хэл бус, харин зөв бичих зүй, хэлзүйн дүрэм зэрэг нь сайтар хэвшин тогтсон боловсронгуй бичгийн хэл байсан нь тодорхой юм. Мөн үүнийг нотлох баримт бол XIV зууны үед монголчуудын ярьж хэлж байсан аман аялгууны баримт дурсгал (монгол үгийг хятад, араб үсгээр авиачлан тэмдэглэсэн дурсгалууд, тухайлбал “*Монголын нууц товчоон*”-ы хятад галиг, “*Мукаддимат Ал-Адаб*” толь бичиг гэх мэт)-ын хэл нь монгол бичгийн хэлнээс ихээхэн зөрөөтэй байгаа явдал болно. Хэлний тийм хувьсал хөгжил хэдэн зуун жилийг туулж байж буй болдог билээ. Энэ мэт баримт нотолгоонд үндэслэн, монголчууд монгол бичгийг хэрэглэж эхэлсэн цаг хугацааг мянган жилээс наашгүй гэж үздэг.

* Монгол Улсын Их Сургууль, Монгол хэл, Соёлын Сургууль

¹ Д. Төмөртоогоо, *Монгол бичгийн хэл*, Монгол хэл шинжлэлийн онол түүхийн асуудлууд, Улаанбаатар, 2002, 292 –р тал.

Оросын алдарт монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов бээр Чингис хааныг “*боловсорчихсон бэлэн бичгийн хэл*”²-ийг Их Монгол Улсын хэмжээнд албан ёсоор хэрэглэж эхэлсэн гэжээ. Тэрбээр монгол бичгийн хэлний хөгжлийг анхлан үечилж,

1. Эртний үе (нэн эрт үеэс XIII зууны эцэс хүртэл)
2. Дундад үе (XIII зууны эхнээс XIV зууны эцэс хүртэл)
3. Орчин үе (XVII зуунаас хойш)

хэмээн хувааж, тухай тухайн үеийн гол онцлогийг судалсан байдаг.³

Үүнээс хойш цөөнгүй судалгаа гарсан бөгөөд монголын эрдэмтэн, академич Д.Төмөртоогоо бээр урьд хождын судалгаа, бичгийн дурсгалын бодот баримт хэрэглэгдэхүүн, зүй тогтолт учир шалтгаан зэргийг нягт нямбай судалж, монгол бичгийн хэлний үечлэлийг *сонгодог бичгийн хэлний өмнөх болон сонгодог бичгийн хэлний* гэсэн хоёр үе болгон үзсэн билээ.⁴

XVII зууны эцэс гэхэд монгол бичгийн хэл маань зөв бичих дүрэм, хэлзүйн тогтолцоо, хэл найруулгын хувьд аль хэдийн бүрэн төгс боловсорчихсон бас харь үгийг тэмдэглэх тогтолцоот галиг үсэгтэй, орчуулгад баримтлах нарийн чанд зарчимтай сонгодог бичгийн хэл болсон билээ. Монгол бичгийн хэлний хөгжил, түүний зөв бичих дүрмийн тухай тодорхой авч үзэхийн тулд монгол хэлнийхээ онцлогийг өгүүлэх ёстой. Монгол хэл бол гарлын хувьд Алтай язгуурын хэл (*үүнд түрэг, манж-тунгүүсийн хэлнүүд багтана. Зарим эрдэмтэд солонгос, япон, хэлийг оруулдаг*) бөгөөд хэв шинжийн гол онцлог нь үг бүтээхдээ, үгийн цөм утгыг хадгалсан язгуур бүтээвэр (*морфем*)-ийн араас үг бүтээх болон хувилгах бүтээвэр (*морфем*)-үүд угсран ордог зүй тогтолтой. Ийм онцлогтой хэлэнд зөв бичих зүйн ямар зарчим тохирох вэ? гэдэг асуулт урган гарна.

Үгзүйн зарчимд тулгуурласан зөв бичих дүрэм нь залгамал хэв шинжтэй (*agglutinative*) хэлний үгийн бүтцийг тодорхой тусгаж, бүтэц, хэв шинжийг найдвартай хадгалж чаддаг. Монголчууд мянган жилийн тэртээгээс эх хэлнийхээ зүй тогтол, хэв шинжид гойд зохицсон, авиалбар зүйн болон үг зүйн зарчмыг тун оновчтой хослуулсан зөв бичих дүрмийг боловсруулж чадсан төдийгүй олон зуун жилийн турш тэрхүү зөв бичих дүрмээ тогтвортой уламжлан хэрэглэсээр өдгөө үед хүрсэн. Ийм учраас монгол бичгийн зөв бичих дүрмээр зөв бичсэн үгсийг үгийн утгат хэсэг буюу бүтээврээр нь задалж үзвэл, монгол үгийн гарал, монгол хэлний язгуур болон залгавар бүтээврийг тов тодорхой харж болдог онцлогтой. Ярианы хэлний хувьсал буюу авиазүйн хөгжил хувьслыг дагуулан зөв бичих дүрмээ өөрчилж, үгийг бүрэлдүүлэгч утгат хэсэг буюу бүтээврийн хэв байдлыг эвдэх ёс монгол бичгийн зөв бичих дүрэмд үгүй тул монгол бичгийн хэлний зөв бичих дүрмээр бичих нь өнөөгийн ярианы хэлнээс нэлээд зөрдөг. Ийм байдал нь эртний бичгийн хэлтэй аль ч улсад тохиолддог билээ.

² Б. Я. Владимирцов, *Работы по Монгольскому языкознанию*, Москва, 2005, стр 430:

“Чингис-хан ввел для нужд своей державы уже готовый литературный язык, язык достаточно фиксированный, изображавшийся при помощи уйгурских букв. Этот письменный язык уже в ту пору отличался от живого, разговорного языка монголов и был языком традиционным.”

(“Чингис хаан улс гүрнийхээ хэрэгцээнд нэгэнт боловсорчихсон бэлэн бичгийн хэлийг хэрэглэсэн юм. Энэ нь уйгур үсгээр тэмдэглэсэн ихэд боловсорчихсон хэл байв. Энэхүү бичгийн хэл нь бүр тэр үед монголын ярианы хэлнээс ялгаатай, уламжлалт хэл байжээ.” Ш. Ч.)

³ Б. Я. Владимирцов, *О трёх периодах Монгольского письменного языка*, Монгольский сборник рассказов из Pancatantra, Пб., 1921, стр. 3-42, 54.

⁴ Д. Төмөртоогоо, *Монгол хэлний түүхэн хэл зүй I*, Улаанбаатар, 1992, 4-37, 49-р тал.

Нэрт монголч эрдэмтэн Г. И. Рамстедт монгол бичгийн хэлний зөв бичих ёсыг, XX зууны эхэн үеийн төв халхын аялгуутай харьцуулан судлаад "... монгол бичгийн хэл бол маш эртний түүхтэй юм. Монгол хэлний үгсийг өдгөө тэмдэглэж байгаа тогтсон бичлэг нь жинхэнэ бодот дуудлагатайгаа дүйж байсан цагаас нааш ярианы хэл нь авиазүйн хувьд ихээхэн өөрчлөгдсөөр яваандаа огт өөр хэлбэртэй болжээ"⁵ хэмээн дүгнэсэн буй.

Г. И. Рамстедтын бичсэнчлэн "Монгол хэлний үгсийг өдгөө тэмдэглэж байгаа тогтсон бичлэг нь жинхэнэ бодот дуудлагатайгаа дүйж байсан цаг" гэдэг бол монгол бичгийн хэл үүсэж бүрэлдэж байсан цаг үе бөгөөд тэр үеийн зөв бичих дүрэм нь цагийн уртад бараг хувиралгүй уламжилсаар ирсэн тул орчин цагийн монгол хэлний олон аялгууны алинтай ч бүрэн тохирохгүй болжээ. Өнөөгийн олон монгол хэл аялгуугаар ярьдаг монголчууд хоорондоо ерийн хэлэлцэхэд ойлгохгүй бэрхшээл гардаг атал харин монгол бичгийн зөв бичих дүрмээр зөв бичсэн зүйлийг бол монгол бичиг мэддэг ямар ч аялгуутан саадгүй ойлгоно. Төв Азийн удам нутагт нүүдэллэн амьдарч ирсэн монгол аялгуутнуудыг холбодог харилцааны хэрэглүүр нь монгол бичгийн хэл юм. Монгол бичгийн хэлний энэ өвөрмөц чадвар нь монголын олон аялгууны онцлогийг үсэгзүйдээ тусгаж чадсан, мөн зөв бичих дүрэм нь олон зуун жилээр тогтвортой хадгалагдан уламжилж, бүх монгол аялгуутан нийтээр дагаж мөрдөж ирсэнд оршино. Монгол бичгийн хэлний зөв бичих дүрмийн энэ онцлог нь эртний монгол хэлний хэв шинжийг тодруулан судлах сайхан боломжийг судлаачдад олгодог.

Монгол бичгийн зөв бичих зүйгээс монгол хэлний үгийн бүтцийг хэрхэн тодруулж болохыг зарим зүйлээр авч үзье.

1. Нэг язгууртай, нэг гаралтай үгсийг хялбар бүртгэж, тухайн язгуураас үүссэн үгсийн утгыг тодлох боломжтой. Жишээ нь:

daru-

<u>darula-</u>	<u>daruyasu</u>	<u>daruy-a</u>
<u>darulal</u>	<u>darulta</u>	<u>daruyaci</u>
<u>darungyui</u>	<u>darumta</u>	<u>daruyala-</u>
<u>darungyuyila-</u>	<u>darumtala-</u>	<u>darusila-</u>
<u>darungyuyilal</u>	<u>darusi</u>	
<u>daruyul-</u>	<u>darumal</u>	
<u>daruyuly-a</u>	<u>darudasu</u>	

Эдгээр үгсийн язгуур бүтээвэр "daru-" гэсэн хэлбэр "дээрээс доошоо хүчлэх" гэсэн гол утгатай үйл үг болох нь зураг шиг харагдаж байна. XIII зууны үеэс тун идэвхтэй хэрэглэгдэж, дэлхийн олон хэлэнд орсон "daruy-a", "daruyaci" хэмээх үг нь "даран ноёлж, захирч тушаах" гэсэн гол утгатай болох нь "daru-" язгуураас илэрхий байна.

2. Монгол бичгийн зөв бичих зүйд, үгийн язгуур бүтээврийн араас угсран залгах дагавар, нөхцөл буюу залгавар бүтээвэр нь чанга, хөндий буюу эр, эм үгэнд залгах хоёр хэлбэртэй бөгөөд ярианы хэлний дуудлага, нутгийн аялгууны онцлогоос хамааруулж, бүтцийг нь үл өөрчилнө. Энэ нь тухайн үгийг бүтцээр нь хялбархан задалж, залгавар бүтээврийн хэв

⁵ Г. И. Рамстедт, *Сравнительная фонетика монгольского письменного языка и Халхаско-Ургинского говора*, Спб, 1908, стр. 1-6.

хэлбэрээр ангилан бүртгэж, утгыг тодлох боломж олгодог. Жишээ нь:

tabaliy (тавлаг)	miqaliy (махлаг)	ebeşülig (өвслөг)
moduliу (модлог)	tosuliу (тослог)	čečeḡlig (цэцэглэг)
eblig (эвлэг)	sikirlig (чихэрлэг)	önggelig (өнгөлөг)
čigiglig (чийглэг)	uqayaliy (ухаалаг)	üşülig (үслэг)
dabusuliу (давслаг)	beyelig (биелэг)	körüşülig (хөрслөг)
činarliу (чанарлаг)	uraliу (урлаг)	ončaliу (онцлог) г.м.
elesülig (элслэг)	bayaturliу (баатарлаг)	

Жишээлсэн үгсийн төгсгөлийн залгавар бүтээвэр нь “-liу/-lig” гэсэн хэлбэртэй, гол төлөв нэр үгээс тэмдэг нэр бүтээдэг дагавар болох нь илт харагдана. Уг дагавар түрэг төрлийн хэлэнд хэлбэр, утга адил байдаг. Гол утга нь тухайн нэр бүхий зүйлээр элбэг дэлбэг шинж байдлыг заана. Энэхүү дагавраар зарим үгийн гарлыг ч тогтоож болно.

Шашны номд “*erlig nom-un qayan*” гэж гардаг. Монгол бичгээрх XVI зууны орчуулгад “*erkelig*” хэмээн тогтвортой бичсэн жишээ олонтаа тохиолдох ба төвд эхтэй нь тулган үзвэл “*erlig nom-un qayan*” гэдгийн “*erlig*” болох нь тодорхой байдаг. “*erkelig*” гэсэн бичлэг эртний хэлбэр нь, “*эрх мэдэл ихтэй, эрх хүч бүхий*” гэсэн утгатай бөгөөд *erkelig* → *erlig* хэмээн хувирсан нь мэдэгдэх бөгөөд эртний түрэг хэлний баримтаар давхар батлагддаг.

3. Монгол бичгийн зөв бичих ёсыг зөвхөн уламжилж тогтсон зуршил гэж үзэж болохгүй. Тэрхүү бичлэгийн тогтсон хэлбэр нь Алтай язгуурын хэлний нийтлэг шинжийг тусгасан жишээ цөөнгүй бий. Жишээ нь:

Монгол бичгийн хэлээр:	Эртний түрэг хэлээр: ⁶	Манж – тунгүүсийн хэлээр: ⁷
buу (буга)	buу [120] олень (буга)	buqu [141]
buqa (бух)	buqa [175] бык-производитель (бух)	buqa [141]
töü (төр)	töü [581] порядок (дэг журам), правило (дүрэм), закон (хууль)	doro [391]
qar-a (хар)	qara [422] чёрный (хар өнгө)	qara [107]
elči (элч)	elči [169] 1. посол (элч), вестник (зарч, мэдээч) 2. важное должностное лицо (чухал албаны хүн), правитель (захирагч)	elčin [39]

4. Монгол бичгийн тогтсон бичлэг болон эртний түрэг хэл, ялангуяа эртний согд, уйгур бичгийн бичлэг тохирох нь элбэг. Энэ нь монгол бичгийн зөв бичих зүй хэлбэршин тогтоход согд, уйгур бичгийн нөлөө их байсны баримт ч мөн болно.

Монгол бичгийн хэлээр:	Эртний түрэг хэлээр:
ada (ад)	ada [7] бедствие (гай тохиолдох), опасность (аюул осол), несчастье

⁶ Эртний түрэг хэлний жишээг “*Древнетюркский словарь*” Академия наук СССР, Институт языкознания., Ленинград., 1969 толиос авч, тухайн үгийн ард хуудасны дугаарыг тавив.

⁷ Манж хэлний жишээг Г.Лувсанжав, Г.Шархүү “*Манж монгол толь*” Улаанбаатар, 1968 толиос авч, тухайн үгийн ард хуудасны дугаарыг тавив.

	(гай тотгор)
adala- (адла-)	adala- [8] <i>причинять беду (гай учруулах)</i>
aулау (аглаг)	aулау [21] <i>безлюдный (эзгүй), уединенный (аглаг зэлүүд)</i>
asiу (ашиг)	asiу [60] <i>польза, выгода, прибыль (ашиг завшаан хонжсоо)</i>
baуla- (багла-)	baуla- [78] <i>привязывать (уях баглах)</i>
bal (бал)	bal [79] <i>мед (зөгийн бал)</i>
baуsi (багиш)	baуsi [82] <i>кит. боиш, бауsi, учитель, наставник (багиш номч)</i>
bulaу (булаг)	bulaу [121] <i>источник (эх булаг)</i>
bulung (булан)	bulung [124] <i>уголь, (в разных знач.) (өнцөг булан)</i>
bütün (бүтэн)	bütün [134] <i>весь, целый, полный, цельный (бүхэл, бүтэн, цул)</i>
ĉау (цаг)	ĉау [139] <i>пора, время (цаг хугацаа)</i>
ĉeĉeg (цэцэг)	ĉeĉäk [143] <i>цветок, соцветие, (цэцэг)</i>
ĉeĉerlig (цэцэрлэг)	ĉeĉäklig [143] <i>цветник (цэцэрлэг), с цветами (цэцэгтэй), имяющий цветы (цэцэг бүхий)</i>
ĉerig (цэрэг)	ĉerig [144] <i>скр. kṣatrika, войско (цэрэг)</i>
ĉоу (цог)	ĉоу [151] 1. <i>блеск (гэрэл, цог, жавхлан), сияние (солнца) нарны туяа</i> 2. <i>пламя (галын дөл), жар (гал цог, ид хав, халуун)</i>
ĉоу jali (цог заль)	ĉоу jalin [151] <i>парн. блеск (цог жавхлан), сияние (туяа)</i>
ĉöb (цөв)	ĉör [155] <i>осадок (тунадас шаар), остатки (үлдэгдэл), выжимки (шавхдас), мусор (хог)</i>
darуу-а (дарга)	darууа [159] < монг. название должности (албан тушаалын нэр): <i>управитель (захирагч)</i>
debter (дэвтэр)	däbtär [159] <i>перс. тетрать (дэвтэр), книга (ном), канцелярское дело (бичиг хэрэг)</i>
ed (эд)	ed [162] <i>имущество (эд таваар), богатство (баялаг)</i>
ed tavar (эд таваар)	ed tavar [162] <i>имущество, богатство</i>
edle- (эдлэ)	edlä- [164] 1. <i>оказывать внимание (анхаарах)</i> 2. <i>использовать (ашиглах), употреблять (хэрэглэх)</i>
titim (титим)	didim [160] <i>созд. dydm < гр. διάδημα, венец, корона (титэм)</i>
enedkeg (энэтхэг)	enätkäk [173] <i>созд* 'yntk'k, 1. Индия (Энэтхэг) 2. индийский (Энэтхэгийн)</i>
erdem (эрдэм)	erdäm [176] <i>достоинство (эрхэм, сайн, үнэт), доблесть (гавьяа), добродетель (сайн гүйл)</i>
erte (эртэ)	ertä [182] <i>рано (эрт), утром (өглөөгүүр)</i>
ertele- (эртлэ-)	ertälä- [182] <i>приниматься за что-л с позаранку (ямар нэгэн юманд хар өглөөгүүр яарах)</i>
esen (эсэн)	esän [183] <i>здоровый (эрүүл энх),</i>
esen tügel (эсэн түгэл)	esän tükäl [183] <i>парн. целый (бүтэн), невредимый (эсэн мэнд)</i>
isi (иш)	iši [214] <i>женицина (эхнэр, эмэгтэй), жена знатного лица (эрх мэдэлт эхнэр), дама (хатан)</i>
yilvi (илбэ)	jelvi [255] <i>волшебство (илбэ), колдовство (увдис)</i>
yirtinĉü (ертөнцү)	jirtinĉü [255] <i>тиб. 'jig-rten, мир, вселенная (ертөнцү, дэлхий)</i>
yirtinĉü daki (ертөнцү дахь)	jirtinĉüdaki [263] <i>находящийся в мире (дэлхий дэх, ертөнцөд оршин буй)</i>
yosun (ёсон)	josun [275] <i>правила (хэв журам), обычай (ёс заншил)</i>
jula (зул)	jula [278] <i>факел, светильник (зул)</i>
kereg (хэрэг)	keräk [300] <i>нужный (хэрэгтэй), необходимый (чухал)</i>
keregle (хэрэглэ)	käräklä- [300] <i>искать (эрэх, бэдрэх), испытывать (сорих үзэх, турших), необходимость (зайлшгүй чухал болох)</i>

otači (оточ)	otači [373] лекарь (эмч оточ)
qamuy (хамаг)	qamuy [416] весь, целый, полный (бүгд, цөм, хамаг)
qarangqu (харанхуй)	qarangqu [424] темный, лишенный света (харанхуй)
qarsi (харш)	qarši [429] дворец (ордон харш)
qula (хул)	qula [469] буланный (о масти лошади) (хул зүс)
qurilta~quriltai (хуралт)	quriltaj [468] народное собрание (олны чуулган)
saqal (сахал)	saqal [486] борода (сахал)
simnu (шимну)	šimnu [523] согд. šmnu, демон, дьявол, (шулмас)
sikir (чихэр)	šākār [522] перс. сахар (чихэр)
tal-a (тал)	tala [528] степь (хээр тал)
tala- (тал-)	tala- [528] грабить, разорять (дээрэмдэх)
tangsuy (тансаг)	taṅsuq [533] удивительный (гайхалтай), необычный (ер бусын)
tekimlig (тэхимлэг)	tegiṁlig [547] достойный (хүндэт, эрхэм)
ayaу-a tekimlig (аяга тэхимлэг)	ajaуqa tegiṁlig [26] достойный поклонения (шүтэн мөргөх зохистой санваартан), досточтимый (нэн эрхэм дээд)
temür (төмөр)	temür [551] железо (төмөр)
tergen (тэргэн)	tergän [554] монг. terge, телега (тэрэг)
ters (тэрс)	ters [555] 1. превратный, неправильный (хуурмаг, тас буруу) 2. сложный, трудный (бэрх төвөгтэй)
turqarу (nasun turqarу)	turqaru [588] постоянно, всегда, беспрестанно, долго (насад, (турхаруу) байнга, үргэлж,)
tuturу-a (тутарга)	tuturṁan [593] рис (цагаан будаа)
ükeg (үхэг)	ükäk [623] 1. погребальныеносилки (оршуулгын дамнуурга) 2. сундук (авдар)
үjüm (үзэм)	üzüm [631] виноград (усан үзэм)
qurmusta(qormusta) (хурмаст)	xormuzda~xormuzta [637] согд. xwrmtz', верховное божество Ормузд, Индра (Хурмаст тэнгэр)
turqay (турхаг)	turqay [587] сторож, страж (харуул манаа)
uruу (ураг)	uruу [615] зерно, семя, косточка (үр тариа, үр хөрөнгө, жимсний үр)
teke (тэх)	tekä [550] козел (тэх)
arslan (арслан)	arslan [55] лев (арслан)
bars (барс)	bars [84] тигр (барс)
kömüldürge (хөмөлдөрөг)	kömüldürük [314] нагрудный ремень лошади (хөмөлдөрөг)
köl- (хөл-)	köl- [314] запрягать (тэргэнд оруулах, тэрэглэх)
tobraу (товрог)	torraq [575] земля, прах, пыль (шороо, тоос)
quvaray (хувраг)	quvraq [475] 1. собрание (чуулган) 2. рел. монашеская община (санваартны чуулган)
bursang (бурсан)	bursan [126] кит. фосэн, буур-сәң <скр. buddha saṅga рел. буддийская монашеская община (буддын санваартны чуулган)
jarliу (зарлиг)	jarliу [242] 1. повеление (зарлиг, айлдаг), предписание (тушаал, заавар), приказ (тушаал) 2. свод религиозных предписаний, сутра (шашины сургаал зарлигийн эмхэтгэл, судар)
јasa- (зас-)	јasa-[245] строить, делать (байгуулах, үйлдэх), устраивать (зохиох, бүтээх)
јimis (жимс)	јemiš [255] фрукт, плод, (жимс)
kkir (хир)	kkir (kir) [311] грязь, сор (хир буртаг, хог)
ubasi (убиш)	upasi [613] согд. wr'su, послушник (гэлэн сахилтан)
ubasanča (убсанц)	upasanč [613] согд. 'wr's'cph, послушник (гэлэнмаа)
јad (МНТ) (жад)	јat [247] чужой, посторонний (харийн, хөндлөнгийн)

jad (зад)	jat [247] колдовство, волшебство, связанные с вызыванием дождя и ветра (бороо салхи урих увдис илбэ)
ṣongqur (singqur) (шонхор)	soṅqur [508] кречет (шонхор)
labai (лавай)	labai [332] кит. лобэй, lua-rai, рожок из раковины (дун)
lingqu-a (лянхуа)	linxua [333] кит. ляньхуа, lien-xua, цветок лотоса (лянхуа цэцэг)
simanaṣa (шимнанц)	ṣimnanṣ [523] согд. <i>ṣm̐ nṣh</i> , монахиня (сахилтан эмэгтэй)
(-ṣibaṣanṣa) (чавганц)	

Дээрх жишээнээс, монгол бичгийн зөв бичих дүрмийн уламжлал өнө эртний тогтсон бичлэгтэй болох нь, *simnu* (шулмас), *yilvi* (илбэ), *ayaṣqa tekimlig* (гэлэн, тө. *dge-slong*), *arслан*, *bars*, *ters*, *bursang quvaray* (бурсан хувраг), *kkir* (хур буртаг), *yirtinṣū* (ертөнц), *qormusta* (хурмаст) гэх мэт үгсийн бичлэгийг харьцуулахад илэрхий байна.

5. Монгол оронд Буддын шашин дэлгэрсэн эртний нэгэн зам нь Энэтхэгээс Дундад Азиар дамжиж түгсэн уламжлал юм. Эртний Согд, Уйгурууд Буддын шашин шүтдэг бас монгол бичгийн өвөг болсон бичгийг хэрэглэж байсан билээ. Чухам энэ үед эртний түрэг хэлэнд Буддын шашны олон зуун үг санскрит хэлнээс орсон ажээ. Эрт цагт монгол хэлэнд орсон санскрит үгийн бичлэг эртний Согд, Уйгурын уламжлалтай бөгөөд олон зуун жил болсон тул ихэд монголжсон байдаг. Жишээ нь:

Монгол бичгийн хэлээр:	Эртний түрэг хэлээр:
asuri (Асури)	asuri [61] скр. <i>asura</i> , рел. класс демонических существ (шулмын амьтны зүйл)
asangi (асанги)	asanki [59] скр. <i>asamkhyeya</i> < <i>asamkhyā</i> , неисчислимое, множество, неисчислимый, длительный (тоолиггүй, цаглашгүй)
adistid (адистид)	adiṣṭit [10] скр. <i>adiṣṭhita</i> , благословение (адис), благодать (буян хишиг)
arsi (арси)	arṣi [55] скр. <i>ṛṣi</i> , святой (хутагт, гэгээн), отшельник (даянч)
biraman (бярман)	braman [119] скр. <i>brahman</i> , брахман (бярман)
čadiy (čedig) (цадиг)	čadik [135] скр. <i>jataka</i> , рел. повествование о прежних перерождениях будды, джатака (Бурхан багшийн урьд төрлийн тухай цадиг)
diyan (дияан)	dijan [160] скр. <i>dskr. asura</i> , рел. класс демонических существ скр. <i>dhyana</i> , будд. размышление (эргэцүүлэн бодох), соцерцание (бясалгал)
dibangyar (divangyar)	dipankari [160] и. <i>собств. первой из двадцати четырех будд, (Дивангар) предшествовавших Гаутаме Будде (Гаутам Буддагийн өмнөх, 24 бурхадын анх тэргүүний алдар)</i>
včir (очир)	včir~vačir [631] скр. <i>vajra</i> , алмаз (очир алмас)
šakimuni (Шагжамуни)	šakimuni [520] скр. <i>śākyamuni</i> , и. <i>собств. легендарный основатель буддизма Гаутамы Шакья-Муни (Буддизмыг үндэслэгч домогт Гаутам Шагжамунийн алдар)</i>
šajin (шажин~шашин)	šazin [521] скр. <i>śāśana</i> , указание (заавар), поучение (сургаал), наставление (номлол)
mandal (мандал)	mandal [336] скр. <i>māṇḍala</i> , магический, заколдованный круг, фигура (ид шидэт, увдист тойрог дүр)
sartavaki (сартваахь)	sartavaxi [490] скр. <i>sārthavāhā</i> , старшина купцов (худалдаачны

erdeni (эрдэнэ)	тэргүүн), предводитель (ахлагч) erdāni [176] скр. ratna, драгоценность (эрдэнэ), сокровище (эрдэнийн сан)
gšan (агшин~эгшин)	kšan [321] скр. kṣāṇa, наикратчайший промежуток времени, момент, мгновение (цагийн хором)
lagšan (лагшин)	lakšan [332] скр. lakṣaṇa, рел. знак, признак (шинж тэмдэг)
nirvan (нирваан)	nirvan [359] скр. nirvāṇa, рел. нирвана, состояние абсолютного покоя, связанное с прекращением перерождений в материальном мире (энэ ертөнцөд дахин төрөхийг тасалж, төгс амгаланг олсон байдал)
baramid (барамид)	paramit [396] скр. pāramitā, будд. добродетели, которые советшаются на пути к достижению состояния будды (Бурхан болохыг зориход төгс эзэмших ёстой буянт үйлс)
sudur (судар)	sutur [515] скр. sūtra, сутра (судар)
šastir (шастир)	šastr [520] скр. śāstra, сочинение (зохиол), трактат (шастир)
buyan (буян)	bujan [120] скр. piṇḍa, благодатный поступок (буянт үйл), благодеяние (сайн үйл)
bodi (бодь)	bodī [107] скр. bodhi, рел. прозрение (гэгээрсэн ухаарал), достижение совершенной мудрости (төгс ухаарлыг олохуй)
abisiγ (авшиг)	abiṣik [2] скр. abhiṣeka, помазание (на трон) (ширээнд суухад тэмдэг тавих); посвящение (авшиг авах), рукоположение в духовный сан (гэгээн хутагт авшиг хүртээх)
abida (Авид)	abita [2] скр. anitābhā, и. собств. Амитаба, самый почитаемый из пяти небесных будд. (Язгуурын таван бурхны эрхэм Авид)
sūmer (sūmber) (сүмбэр~сүмэр)	sumir [513] (sumeri) название, горы, считающейся у буддистов центром вселенной (Буддын ёсоор ертөнцийн төвд орших уулын нэр)
tarni (тарни)	darni [159] скр. dhāraṇī, рел. магическая формула, заклинаниех (шидэт уншлага, урилга шивилэг)
γarudi (гарди)	garuḍi [194] скр. garuḍa, рел. мифическая птица с золотыми крыльями, царь-птица (алтан далавчтай домгийн шувуу, шувуудын хаан)
maqabod (махбод)	maqabut [338] скр. mahābhūta, рел. четыре великих, или универсальных, первоэлементов (земля, вода, огонь, ветер) (түгээмэл орших, агуу их, анхдагч элемент /иороо, ус, гал, хий/)
mutur (мутар)	mudur [347] скр. mudrā, способы ритуального складывания рук (мутрын ходолгөөнөөр үзүүлэх шашины зан үйлийн арга)
baday (бадаг)	patak [396] скр. pādaka, стих (бадаг)
payud (наяд)	pajut [354] скр. pajuta, очень большое количество, мириады (тоолиггүй их, 10 ¹¹)
gaqu (раах)	rahu [477] скр. rāhu, планета Раху в индийской астрологии (Энэтхэгийн одон орны судлалын Раху гараг)
šlok (silüg)	šlok [524] скр. śloka, стихи (шүлэг)
sansar (сансар)	sansar [484] скр. saṃsāra, рел. сансара, круговращение бытия (орчлон)
samadi (самади)	samati [483] скр. samādhi, рел. название вида религиозного созерцания (шачны нэгэн зүйл бясалгалын нэр)

Эртний түрэг хэлэнд санскрит хэлнээс орсон 600 шахам үгийг бүртгэж үзэхэд, Бурхан багшийн намтар цадигтай холбоо бүхий газар орон, хот балгад, бурханы шашны сахил

санваар, номлол сургаал, бурхан бодисадва нарын нэр тэргүүтэй өргөн хүрээг хамарсан байх бөгөөд бүгд монгол бичгийн хэлэнд эрт орсон болох нь ажиглагдав. Энд зөвхөн цөөн жишээг эш татан үзүүлэв.

Нэгэн зүйлийг тэмдэглэхэд, XVI дугаар зууны үеэс төвдөөр дамжиж монголд Бурханы шашин их хүчтэй дэлгэрэх цагт санскрит үгс төвд галигаар монгол хэлэнд оржээ. Тэдгээр үгс санскрит хэлний дуудлага бичлэгтэйгээ ихэд ойр, бас харь үг болох нь танигдахуйц бичлэгтэй байдаг.

6. Монгол хэлний урт эгшгийн гарал үүслийн асуудал нь монгол бичгийн зөв бичих зүй болон орчин цагийн монгол хэлний зөв дуудах зүй хоёрын гол ялгаа болдог төдийгүй монгол хэлний авианы тогтолцоонд гарсан том өөрчлөлт юм. Тийм учраас, XIX зууны дунд үеэс гадаад, дотоодын А.А.Бобровников, Г.И.Рамстедт, Б.Я.Владиморцов, Г.Д.Санжеев, Н.Поппе, Ш.Хаттори, Л.Лигети, Ш.Лувсанвандан, Д.Төмөртоогоо нарын олон эрдэмтэн энэ сэдвийг судалжээ.

Монгол бичгийн зөв бичих ёсоор $V+C+V$ (эгшиг+гийгүүлэгч+эгшиг) гэж бичдэг цогцоос орчин цагийн монгол хэлний урт эгшиг буюу $V+V$ гэсэн бүтэц хэрхэн бий болсныг хамгийн сүүл үеийн судалгаагаар томъёолбол:

$$V+C+V \rightarrow V+C+\bar{V} \rightarrow V+C^*+\bar{V} \rightarrow V+'+V \rightarrow \bar{V}$$

Жишээ үгээр үзүүлбэл:

$$a\bar{y}\bar{u}la \rightarrow a\bar{y}\bar{u}la \rightarrow aw\bar{u}la \rightarrow a'\bar{u}la \rightarrow \bar{u}la$$

Монгол хэлний урт эгшгийн гарал үүслийг XIX зууны дунд үеэс өдгөө хүртэл судалж дээрх зүй тогтолг хувьслыг олж тогтоосон байтал, сүүл үед зарим судлаачид, эртний монгол хэлэнд байсан урт эгшгийг монгол бичигт тэмдэглэх арга нь $V+C+V$ (эгшиг гийгүүлэгч эгшиг) гэсэн үсгийн нийлц юм гэж дурдаж байна. Энэ санал үнэнд нийцэхгүй болохын хангалттай хариуг монгол бичгийн хэлийг Алтай язгуурын хэлтэй харьцуулан олж болно. Жишээ нь:

Монгол бичгийн хэлээр:	Эртний түрэг хэлээр:
ariγun (ариун)	ariγ [51] <i>чистый, незагрязненный, чисто (ариун, хиргүй)</i>
buγudai (буудай)	buγdaj [120] <i>пишеница (буудай)</i>
bilegüü (билүү)	bilägü [99] <i>точильный камень (билүү)</i>
birayu (бярүү)	buzayu [130] <i>теленок (тугал)</i>
imaγ-a (ямаа)	imγa [218] <i>коза (ямаа)</i>
jaγan (заан)	jaγan [224] <i>слон (заан)</i>
jige (зээ)	jegän [252] <i>племянник (ач, зээ)</i>
jegerde (зээрд)	jegrän [753] <i>гнедой, рыжий (зээрд)</i>
qaγan (хаан)	qaγan [405] <i>каган, верховный правитель, главный хан (дээд эзэн, хаан)</i>
qaγur- (хуур-)	qaγur- [406] <i>жарить, калить (хуурах, шарах)</i>
qaraγul (харуул)	qaraγu [424] <i>дозор, передовое охранение (харуул, манаа)</i>
qataγu (хатуу)	qatγ [433] <i>твердый, жесткий, крепкий (хатуу, ширүүн, бат бэх)</i>
qoriγan > qoriyan военный (хороо)	qoriγan [458] <i>(ст-монг. qoriya[n]~ qoriγa[n]) стан, лагерь (цэргийн хуаран, хороо)</i>

qobuyu (ховоо)	qovya [461] ведро, бадья (хувин, ховго)
taγar (таар)	taγar [526] мешок, торба (өрмөг, шуудай)
tegerm-e (тээрэм)	teγirmän [548] мельница (тээрэм)
jiγuy-a (жороо)	joγiya [274] иноходец (жороо)
jundayul (МНТ) (жундуул)	jundaq [281] лошадиный помет, навоз (адууны хомоол)
say-a- (саа-)	say [480] доить (мал саах)
sayam (саам)	sayim [480] удой (сүү саам)
sayari (саарь, булигаар)	sayri [481] кожа со спины животного (амьтны зооны арьс)
quyur (хуур)	qubuz<qobur ⁸ [51] струнный музыкальный инструмент (чавхдаст хөгжмийн зэмсэг)
kirayu (хяруу)	qirayu ⁹ [48] иней (хяруу, шүүдэр)
tuula< tuyula (туул гол)	toyla [571] приток Орхона (Орхон голд цутгах гол) 712-716 оны хооронд сийлсэн Тоньюкукийн хөшөөний бичээст буй.

Монгол бичгийн хэлээр:

ayali (ааль)
 aγay-a (араа)
 aγiy-a (ачаа)
 bayatur (баатар)
 büriyesü (бүрээс)
 görügесü (гөрөөс)
 güjige (гүжээ)
 gegegen (гэгээн)
 dabay-a (даваа)
 deligüü (дэлүү)
 noγuyan (ногоон)
 serigün (сэрүүн)
 ulayan (улаан)
 üliye- (үлээ-)
 imay-a (ямаа)

Манж-түнгүүсийн хэлээр:¹⁰

ma. ageli
 ma. argan
 ma. aciha
 эвенк. bagadi; эвен. baytir
 ma. burgiyen
 ma. gurgu
 эвенк. gudige; сол. gudege
 ma. genggiyen
 ma. dabayan
 ma. delihun; үд. deligi
 ma. niowanggiyan
 ma. serguwen
 ma. fulgiyan
 ma. fulgiye-
 эвенк. inayan; сол. imaya; нег. imaga

Дээр харьцуулсан жишээнд авиазүйн зарим хувьсал өөрчлөлт байгаа боловч, орчин цагийн монгол хэлний халх аялгууны¹¹ урт эгшигтэй дүйх хэсэгт “γ, g, y, b” зэрэг гийгүүлэгч байсан нь тодорхой байна. Тэдгээр гийгүүлэгчийн суларсан үеийг ч тусгасан зүйл ажиглагдана. Бидний авсан жишээ нь аль нэг хэлэндээ орсон үг байж болно. Тийм байлаа ч гэсэн монгол бичгийн хэлний зөв бичих дүрмээр V+C+V гэж тэмдэглэсэн цогц нь урт эгшгийг тэмдэглэх арга бус, эртний монгол хэлний авиазүйн тогтолцоот хэв шинж байсны нуталгаа хэвээр байх болно.

⁸ В. И. Рассадин, "Очерки по истории сложения тюрко-монгольской языковой общности, Часть I, Тюркское влияние на лексику монгольских языков, Элиста, 2007.

⁹ Мөн дээрх зохиол.

¹⁰ Манж-түнгүүс хэлний жишээг Э.Мөнх-Учрал, Манж, Монгол хэлний урт эгшигийг язгуур дүйх үгсийн хүрээнд харьцуулах нь, Acta Mongolica, Volume V (246), МУИС, Монгол судлалын төв, Улаанбаатар, 2005., 97-105-р тал өгүүллээс авав.

¹¹ Энд халх аялгуу гэж тодотгон бичсэний учир нь зарим монгол хэл, аялгуунд хоёр эгшгийн дундах гийгүүлэгч хадгалагдсаар буй. Жишээ нь: Буриадын зарим аялгуунд “нуруу”-г “ниγуаγ”, хурууг “’qигуаγ” гэж хэлдэг.

6. Алтай язгуурын хэл, тухайлбал монгол, түрэг хэлэнд адил байдаг үг бүтэх ёсыг ашиглан, монгол бичгийн хэлний зарим үгийн язгуурын утгыг тодотгож болно.

Хоёр хэлэнд адил байх нэгэн үг бүтэх загвар:

	V	+	γ /g/	=	N
монгол бичгээр:	budu	+	γ	=	buduy
эртний түргээр:	bodu	+	γ	=	boduy
	[107]				[108]
	<i>красить, окрашивать</i> (будах)				<i>краска, цвет</i> (өнгө зүс, будаг)

Энэ загвараар бүтсэн монгол бичгийн хэлний үгийн язгуурыг тодолж болох жишээ:

Монгол бичгийн хэлээр:	Эртний түрэг хэлээр:
emgeg (emge+g) эмгэг	emgä- [172] мучиться (тарчлах, шаналах, зүдэх)
sürüg (sür(ü)+g) сүрэг	emgäk [172] мученое (зовлон, зүдүүр), тягость (төвөг яриуиг)
bölüg (böl(ü)+g) бүлэг	sür- [517] 1. вести (хөтлөх дагуулах), 2. знать (хөөх, туух), преследовать (мөрдөх мөшгих) sürüg [518] стадо, табун (мал сүрэг)
keseg (kese+g) хэсэг	böl- [117] делать (үйлдэх, болгох), разделять (хуваах таслах)
bilig (bili+g) билэг	bölik [117] часть (анги, бүлэг), доля (хувь хэсэг)
qudury (qud(u)+γ) (quddury) худаг	kes- [302] резать (огтлох таслах), делать (үйлдэх болгох)
tayaγ (taya+γ) таяг	kesäk [302] кусок (хэсэг, хэрчим, зүсэм)
körüg (kör(ü)+g) хөрөг	bil- [98] знать, ведать (таних, мэдэх, ойлгох, ухаарах)
kösig (kösi+g) хөшиг (kösigе)	bilig [99] знание (эрдэм ухаан, мэдлэг)
	qud- [463] лить (ус асгах, цутгах)
	qudury [463] колодец (худаг)
	taja- [527] прислонять (түшигтлэх), ставить опору (тулгуур хийх)
	tajaq [527] 1. палка (саваа, бэрээ), посох (таяг) 2. опора (тулгуур), основа (үндэс)
	kör- [317] видеть, смотреть (үзэх, харах)
	körk [317] оброз (дүр), изображение (хөрөг, дүрс)
	köši- [319] закрывать (хаах), заслонять (халхлах)
	köšik [319] покрывало (бүтээлэг, нөмрөг), занавес (хөшиг)

Өмнө жишээ болгосон монгол бичгийн хэлний үгсийн язгуур бүтээврийн утгыг эртний түрэг хэлнээс тодруулах боломж олдож байна. Үүсмэл үг нь орчин цагийн монгол хэлэнд идэвхитэй хэрэглэгдэж байгаа боловч, язгуур бүтээврийн эртний утга нь мартагдсан ажээ.

Товч дүгнэлт

1. Монгол бичгийн хэл, түүний зөв бичих дүрэм нь монгол хэлний хөгжлийн эртний үеийн онцлогийг тусгасан төдийгүй тогтвортой хадгалж ирсэн бөгөөд “энэ ч чанараараа монгол хэлний сэтгэлгээний мөн чанар хийгээд монгол хэлний хөгжлийн зам мөрийг бидний үед тээж авчирсан гэдгийг тэмдэглэвэл зохино. Үгийн үүсэл, бүтэц, хэлбэр, утгыг тэнхрүүлэн сэргээхэд тулгуур баримт болж өгдөг.”¹²

¹² Ц. Шагдарсүрэн, *Үсэг зүйн судалгаа*, Монголчуудын үсэг бичигийн товчоон, Улаанбаатар, 2001, 41-р тал.

2. Монголчууд, монгол бичгийг хэрэглэж эхлэхдээ, залгамал (agglutinative) хэлний онцлогт сайтар зохицдог үгзүйн зарчимд тулгуурласан зөв бичих зүйгээ боловсруулж, улмаар олон зуун жил өөрчлөлгүйгээр нийтээр даган мөрдөж ирсэн тул монгол хэлийг цуваа цагийн үүднээс дорвитой судлах гэвэл монгол бичгийн зөв бичих зүйг юун түрүүнд анхаарах ёстойг онцлон үзүүлэхийг зорив.
3. Алтай язгуурын хэлний онолын талаар судлаачид өөр өөр саналтай байдаг. Эрт цагт нэг хэл байсан, эсвэл олон мянган жил хамт нутаглаж, хэлний талаар харилцан нөлөөлсөн алин байлаа ч гэсэн монгол хэлний эртний онцлогийг судлахад монгол бичгийн хэлийг алтай язгуурын хэлний зохих хэрэглэгдэхүүнтэй зайлшгүй харьцуулан үзэх нь чухал болохыг энэ өгүүлэлд анхаарсан болно.
4. Ер нь авиазүй, үгзүй, үгийн утга судлал гээд монгол хэлний аль ч түвшиний судалгаанд зөвхөн цуваа цаг төдийгүй, зарим тохиолдолд хам цагийн үүднээс авч үзсэн байлаа ч, монгол бичгийн хэлний зөв бичих зүйн бичлэгийг зайлшгүй анхаарах шаардлагатай байна. Гэтэл зарим судлаачийн харьцуулсан хэл шинжлэлийн зохиол бүтээлд, тэр тусмаа Алтай язгуурын хэлний хүрээнд харьцуулан бичсэн зүйлд орчин цагийн халх аялгууны жишээг кирилл үсгийн бичлэгээр нь жишээ болгон аваад монгол бичгийн хэлний баримтыг орхигдуулах дутагдал тохиолдсоор байгааг эрхбиш засаж залруулах хэрэгтэй байна.